**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2022 он)**

2022 оны 02 дугаар сарын 16 Номгон

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 13 | 13 | Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 2, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, төрийн албанд анх томилогдсоны дараах сургалтад 3, Удирдлагын академийн богино хугацааны зорилтод сургалтад 10, Засгийн газрын зорилтод 2 удаагийн сургалтад төрийн захиргааны 41 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн байгууллагын албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм, холбогдох хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран цахимаар зохион байгуулсан. Албан хаагчдын 73,8 хувь нь мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлийн дотоод сургалтад хамрагдсан. |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 8 | 8 | |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 5 | 5 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | - | - | |
| | | | Бусад | - | - | |
| | | 1.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 84 | 62 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 48 | 41 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 36 | 21 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 11 | 10 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 73 | 52 | |
| | | 1.3. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: | 90-ээс дээш | 73,8 % | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийт албан хаагчдад эзлэх хувь | | | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гадаад сургалт зохион байгуулагдаагүй. |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1. | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | - | | |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | | |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | - | | |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | - | 784,000 | Ковид-19 цар тахлын халдварын нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу сургалтын зардал хэмнэлтийн горим шилжсэн. |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | 9.7% | Мэргэшсэн 4 албан хаагч буюу нийт мэргэшсэн албан хаагчдын 9.7 хувь нь шилжсэн байна. |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | 45% | 45% | Байгууллагаас салбарын шагналаар 1 албан хаагч шагнагдсан. “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу 2020 онд 5 албан хаагчид дэс түшмэлийн дөтгөөр зэрэг шинээр олгож, 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу архивын ажилтанд олгох мөнгөн урамшууллыг журмын шаардлагыг хангасан төрийн архивын тасгийн 2 ажилтанд олгосон.<br>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлэх үнэлгээний баг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/192 дугаар тушаалаар шинэчлэгдэн байгуулагдаж, холбогдох саналыг төсвийн шууд захирагчид уламжилж албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. Зэрэг дэвийг ахиулан олгох 7 албан хаагчийн мэдээллийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. Албан хаагчдын цалингийн нэмэгдлийг 2022 оны А/01 тушаалд тусган шийдвэрлэлээ. |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 3000 | 3000 | Албан хаагчдад өдрийн хоолны мөнгө, томилолт, унааны зардлыг төсвөөс бүрэн олгож ажилласан байна.<br>Үүнд:<br>• Хоолны хөнгөлөлт ажлын өдөр албан хаагч бүр 3000 төгрөг, бүгд 59.2 сая<br>• Томилолт унааны зардалд – 29..2 сая |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80-аас дээш | 80.2% | Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллыг сайжруулахын тулд байгууллагын орох хаалганд халуун хэмжих, ариутгалын төхөөрөмж болон ариун цэврийн өрөөнд ус халаагч бойлуур шинээр байршууллаа. Байгууллагын дотор орчин болон гадна талбайн зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.<br><br>Албан хаагчдын амралтын өрөөг бүрэн тохижуулж ажилчдын ая тухтай байдлыг ханган кофе чанадаг машиныг шинээр авч байршуулсан.Мөн байгууллагын үйлдвэрчний эвлэлээс ажилтан, албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч массажны сандал амралтын өрөөнд байршуулахаар ажиллаж байна.<br><br>Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд хийгдсэн ажилд ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин 80,2 хувьтай. |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 1-ээс дээш | 2 удаа | Байгууллагууд албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр томуугийн вакцинд хамруулж, дархлаажуулалтыг дэмжих зорилгоор витамин, эмчилгээний багцаар 2 удаа хангасан. Коронавируст халдвараар өвчилсөн нийт албан хаагчийг эмчлүүлэх нөхцөл боломжоор хангаж цалинг бүтэн олгож, 41 албан хаагч тус бүр 100.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>(Нийт зарцуулагдсан зардал 6.100.000 төгрөг) |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 90-ээс дээш | 100% | Дээрх арга хэмжээнд байгууллагын бүх албан хаагчид бүрэн хамрагдсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | - | 130.251.000 | Байгууллагын хамтын гэрээ, дотоод журамд заагдсан нэг удаагийн тусламж, дэмжлэгийг тухай бүр шуурхай шийдвэрлэж нийт 34.967.000 төгрөг, мөн албан хаагчдын сургалт хөгжил,урамшуулал, хоол унааны нэмэгдэл, томилолт, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зардал зарцуулж, албан хаагчдын нийгмийн асуудалд нийт 130.251.000 мянган төгрөгийг зарцуулсан байна. /Цалингийн зардал тусгагдаагүй/ |

____oOo____